

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД, МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2020 оны ... сарын  
... ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Аюулгүйн бүс, түүний дэглэмийг тогтоох журам батлах тухай  
/Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис, тэсэлгээний  
хэрэгслийн үйлдвэр болон хадгалах байр, агуулахын/

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай  
хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Аюулгүйн бүс, түүний дэглэмийг тогтоох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр болон хадгалах байр, агуулахын аюулгүйн бүс, түүний дэглэмийг тогтоох журмын хэрэгжилтийг газар дээр нь зохион байгуулж, гарсан шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Мөнхтөр/, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газар /Н.Батбаяр/-т даалгасугай.

УУЛ УУРХАЙ, ХҮНД  
ҮЙЛДВЭРИЙН САЙД

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

Д.СУМЪЯАБАЗАР

Н.ЦАГААНХҮҮ

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.НАНДИНЖАРГАЛ

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА

Б.МӨНХТӨР

ТЗУГ-ийн ХХ-ИЙН ДАРГА

Д.ЛХАМЖАВ

Боловсруулсан: УУХ-ийн шинжээч

Б.Дашбал

*Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд  
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын  
2020 оны .... сарын ... өдрийн ..... дугаар  
хамтарсан тушаалын хавсралт*

## **Аюулгүйн бүс, түүний дэглэмийг тогтоох журам**

### **Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийг үндэслэн холбогдох бусад дүрэм, журам, заавар, стандартын шаардлагад нийцүүлэн тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр болон хадгалах байр, агуулахын аюулгүйн бүс, түүний дэглэмийг тогтоох, тэсэлгээний ажлыг механикжуулах тоног төхөөрөмж, тэсэлгээний багаж, хэмжүүр, аппарат хэрэгслийг туршин хэрэглэх нөхцөл болон хэрэглэх баталгаат хугацаа нь дууссан тэсрэх материалын талаар дүгнэлт гаргахад оршино.

1.2. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, тэсэлгээний явуулах, ашиглах аж ахуйн нэгж нь (цаашид “компани” гэх) тэсрэх бодисын үйлдвэр болон хадгалах байр, агуулахад аюулгүйн бүс тогтоолгох, тэсэлгээний ажлыг механикжуулах тоног төхөөрөмж, тэсэлгээний багаж, хэмжүүр, аппарат хэрэгслийг талаар Геологи уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргах, аюулгүйн бүс тогтоох, ашиглалтын дүгнэлт гаргах ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) томилох, ажлын хэсэг тэсрэх бодисын үйлдвэр болон хадгалах байр, агуулахыг ашиглалтад хүлээн авах, аюулгүйн бүс тогтоох, тэсэлгээний ажлыг механикжуулах тоног төхөөрөмж, тэсэлгээний багаж, хэмжүүр, аппарат хэрэгслийн ашиглалтад дүгнэлт гаргахад энэхүү журмыг мөрдөнө.

### **Хоёр. Ажлын хэсгийн зохион байгуулалт, бүрэлдэхүүн**

2.1. Ажлын хэсгийг дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:

2.1.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Мэргэжлийн зөвлөлийн даргын баталсан хөдөө, орон нутагт ажиллах ажлын удирдамжийн дагуу байгуулсан ажлын хэсэг уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, зэвсэгт хүчин, тагнуул, цагдаа, онцгой байдал, мэргэжлийн хяналт болон ашигт малтмал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас томилсон бүрэлдэхүүнтэйгээр тэсэлгээний зориулалттай тоног төхөөрөмжийн ашиглалтын дүгнэлт гаргаж, мөн тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр болон хадгалах байр, агуулахын аюулгүйн бүсийг тогтооно.

2.2. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийг ашиглалтанд оруулах, тэсэлгээний ажлыг механикжуулах тоног төхөөрөмж, тэсэлгээний багаж, хэмжүүр, аппарат хэрэгслийн ашиглалтад дүгнэлт гаргахад энэхүү журмын 2.1.1-д заасан бүрэлдэхүүн ажиллаж тэмдэглэл хөтлөн, мэргэжлийн чиглэлээр санал, дүгнэлт гаргаж, албан даалгавар өгч, батлагдсан зааврын дагуу бүх гишүүдийн гарын үсэг бүхий нэгдсэн шийдвэр гаргана.

2.3. Ажлын хэсэг нь тэсрэх бодисын үйлдвэр болон хадгалах байр, агуулахын аюулгүйн бүсийг тогтоож тухайн объектын байршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад энэ тухай албан тоотой мэдэгдэж байна.

2.4. Аюулгүйн бүсийн дүгнэлт, акт хэвлэмэл хуудсан дээр Мэргэжлийн зөвлөлийн тэмдэгээр баталгаажсан байна.

### **Гурав. Үйлдвэр болон агуулахын аюулгүйн бүс, түүний дэглэмийг тогтоох, аюулгүй зайг тодорхойлох аргачлал**

3.1. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэх үйлдвэр болон хадгалах байр, агуулахын аюулгүйн бүсийг тогтоохдоо тухайн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын хүчин чадлаас нь хамааруулж газар дээр нь хэмжилт хийж тогтооно.

3.2. Аюулгүйн бүс, түүний дэглэмийг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасны дагуу тогтооно.

3.3. Аюулгүйн бүсэд хүн ам суурьших, барилга байгууламж барихаас сэргийлж, бусад хэтийн төлөвлөлтийг бүсээс гадна байх зарчмыг баримталж ажиллана.

3.4. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр болон хадгалах байр, агуулахаас хүн ам суурьшсан хот, суурин, авто болон төмөр зам, үйлдвэр, байгууламж, тэсрэх болон шатах аюултай материалын агуулах, улсын чанартай байгууламж хүртэлх аюулгүй зайг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд заасны дагуу тодорхойлно.

3.5. Тэсэлгээний ажлыг механикжуулах тоног төхөөрөмж, тэсэлгээний багаж, хэмжүүр, аппарат хэрэгслийн ашиглалтад дүгнэлт гаргахад шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулж болно

### **Дөрөв. Аюулгүйн бүс тогтоолгох компанийн эрх, үүрэг**

4.1. Үйлдвэрлэлийн зориулалттай тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр болон хадгалах байр, агуулахад аюулгүйн бүс тогтоолгох, тэсэлгээний ажлыг механикжуулах тоног төхөөрөмж, тэсэлгээний багаж, хэмжүүр, аппарат хэрэгслийн ашиглалтад дүгнэлт гаргах тухай хүсэлтийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хүргүүлэх ба хүсэлтэд тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр болон хадгалах байр, агуулахын эргэн тойрон дахь тухайн үеийн зургийг буулган, дэлгэрэнгүй танилцуулга, тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, гаалийн бүрдүүлэлт, холбогдолтой стандарт, тухайн тоног төхөөрөмж дээр ажиллах боловсон хүчний мэдээлэл, туршилт шинжилгээ хийсэн бол тухай бүр томилогдсон ажлын хэсгийн тушаал, шийдвэр, туршилт шинжилгээний ажлын тайлан, актыг тус тус хавсаргасан байна.

4.2. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр болон хадгалах байр, агуулахын аюулгүйн бүс тогтоох, тэсэлгээний ажлыг механикжуулах тоног төхөөрөмж, тэсэлгээний багаж, хэмжүүр, аппарат хэрэгслийн ашиглалтад дүгнэлт гаргах ажлын хэсгийн тухайн объектод ажиллахад гарах зардлыг тухайн хүсэлт гаргасан компани хариуцна.

### **Тав. Орон нутгийн засаг захиргааны эрх, үүрэг**

5.1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т заасны дагуу шинээр баригдах тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр болон хадгалах байр, агуулахын байнгын байршлыг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.

5.2. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр болон хадгалах байр, агуулахад аюулгүйн бүс тогтоох ажлын хэсгийг ажиллах ажлын нөхцөлөөр хангана.

5.3. Хот суурин, орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийг судалж, тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад газар олгохгүй байх үүрэг хүлээнэ.

5.4. Хэрэв аюулгүйн бүсийн хил, хязгаарт газар олгосон бол түүнийг өөр аюулгүй газарт шилжүүлэх арга хэмжээ авна.

5.5. Орон нутгийн засаг захиргаа нь тухайн компаниас холбогдох хуульд заасны дагуу газар болон ус ашигласны төлбөрийг бүрэн авна.

#### **Тав. Бусад**

6.1. Аюулгүйн бүс, түүний дэглэмийг тогтоохтой холбоотой маргаантай асуудал гарвал уг асуудлаар тухайн компани шүүхээр шийдвэрлүүлнэ.

----- о О о -----